

ХЯТАДЫН “ЭНХ ТАЙВАНЧ СЭРГЭН МАНДЛЫН” ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ц.Батбаяр*

БНХАУ-ын Ерөнхий сайд Вэнь Зябао 2003 оны 10 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд Индонезийн Балид болсон АСЕАН+3, АСЕАН +1 болон БНХАУ, Япон, БНСУ-ын удирдагчдын 5 дахь удаагийн дээд хэмжээний уулзалтанд оролцож “Зүүн Азийн хамтын ажиллагааны шинэ бүлгийг нээх нь” нэртэй үг хэлэв. Вэнь Зябао өнгөрсөн хэдэн жилд АСЕАН+3 бүлгийн хамтын ажиллагаа өргөжиж жирийн нэг яриа хэлэлцээний шатнаас бүрэн хэмжээний хамтын ажиллагааны механизмын түвшинд очсоныг тэмдэглэв. Тэрээр хэлсэн үгэндээ Зүүн Азийн чөлөөт худалдааны бүс байгуулах судалгаа хийх, Зүүн Азийн санхүүгийн хамтын ажиллагааг өргөтгөх, бүс нутгийн улс төр - аюулгүй байдлын яриа хэлэлцээг тогтмолжуулах, нийгэм, соёл, шинжлэх ухаан технологийн салбарт хамтын ажиллагааг өргөтгөх зэрэг дөрвөн саналыг дэвшүүлсэн байна.

Хятадаас Азийн орнуудтай хийх худалдаа, хөрөнгө оруулалт байнга өсч байна. 2003 онд Хятад улс Азийн орнуудаас 272,9 тэрбум ам долларын барааг импортлосон нь өмнөх оныхоос 42,4 хувиар өссөн байна. Үүний дотор АСЕАН, Япон, БНСУ, Энэтхэг зэрэг орноос оруулдаг Хятадын импорт 35 хувиар өсчээ. Хятадаас Азийн орнуудад оруулж байгаа шууд хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд жилд дунджаар 20 хувь нэмэгдэж байна. 2003 онд Хятадаас гадагшаа 20 сая хүн аялал жуулчлалын зорилгоор зорчсоноос дийлэнх нь Азийн чиглэлд зорчсон байна.

Зүүн Азийн бүс нутаг урт удаан хугацааны турш энх тайван, тогтвортой орчин, нөхцлөө хадгалж чадах эсэхээс Хятадын эдийн засгийн бүтээн байгуулалт, шинэчлэлийн бодлогынх нь хэрэгжилт шууд хамааралтай гэж БНХАУ-ын 4 дэх үеийн шинэ удирдлага үзэж байна. Бүс нутгийн том гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчил, давхцал нь тус бүс нутгийн байдал хямрах, намжих үйл явц ээлжлэн өрнөхийн гол шалтгаан болж байна. БНХАУ бүс нутгийн орнуудын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд олон үе шаттай, олон талын, олон хэлбэрийн хамтын ажиллагаа, яриа хэлэлцээг уйгагүй эхлүүлэн хөгжүүлснээр харилцан итгэлцлээ нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангаж чадна гэсэн үзэл санааг баримтлан АСЕАН-ы Бүсийн чуулга / АРФ /, Ази, Номхон далайн аюулгүй байдлын хамтын ажиллагааны зөвлөл / CSCAP /, Солонгосын асуудлаархи “зургаан талын яриа хэлэлцээ”, БНХАУ, АНУ, Японы 3 талын бага хурал болон аюулгүй байдлын бусад олон талын арга хэмжээнд идэвхтэй оролцож байна.

Бүс нутгийн нөлөө бүхий гүрнүүдтэй харилцаагаа зохицуулах талаар сүүлийн жилүүдэд идэвхитэй ажиллаж Хятад-Оросын хооронд “эрх тэгш, итгэлцсэн, ХХI зуун руу чиглэсэн урт хугацааны тогтвортой сайн хөршийн найрсаг харилцаа”, Хятад-Японы хооронд “ирээдүйд чиглэсэн урт хугацааны тогтвортой сайн хөршийн найрсаг харилцаа”, Хятад-АНУ-ын хооронд “ХХI зуунд чиглэсэн бүтээлч стратегийн

*Ц.Батбаяр. Түүхийн ухааны доктор (Sc.D)

түншлэлийн харилцаа”-г тус тус тунхаглан хөгжүүлж байна.

БНХАУ-ын Ерөнхийлөгч Ху Жиньтао 2004 оны 4 дүгээр сард болсон Боао-ийн чуулга уулзалтын нээлтэн дээр хэлсэн үгэндээ хэд хэдэн чухал санал дэвшүүлснээс бүс нутгийн эдийн засгийн интеграцийг гүнзгийрүүлэх, соёлын солилцоог өргөжүүлэх, аюулгүй байдлын асуудлаархи яриа хэлцээ болон цэргийн салбарын солилцоог өргөтгөх саналууд нь олны анхаарлыг ихэд татав. Тэрээр хамтын итгэлцэл, эрх тэгш байдал болон хамтын ажиллагааны зарчимд тулгуурласан аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалаа тууштай баримтлахаа илэрхийлж, өнөөгийн бүс нутгийн аюулгүй байдлын олон талт механизмуудыг бүрэн дүүрэн ашиглах эрмэлзлээ цохон тэмдэглэв. БНХАУ Азийн бусад орнуудтай цэргийн аюулгүй байдлыг хэлэлцдэг механизм буй болгох, цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх чиглэлд идэвхтэй ажиллахад бэлэн байгаагаа нотлов.

Энэ жилийн Боао-ийн чуулга уулзалтын нэг онцлог нь олон жилийн турш Өрнөдөд яригдаж бараг хэвшил шахуу болсон “Хятадын аюул занал” (The China Threat) гэсэн үзэл баримтлалын эсрэг “Хятадын энх тайванч сэргэн мандал” (Peaceful Rise of China) гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлж, Боао-ийн индрээр дамжуулан дэлхийн хамтын нийгэмлэгт хүргэх, итгүүлж үнэмшүүлэх агуулга хадгалж байв.

Энэхүү үзэл баримтлалыг анх Шанхайн эрдэмтэд судлаачид дэвшүүлсэн бөгөөд ХКН-ын Намын дээд сургуулийн дэд захирал байсан Жэнь Бизян уг үзэл баримтлалын онолын үндэслэлийг боловсруулсан байна. Ерөнхийлөгч Ху Жиньтао 2003 оны эцсээр болсон Мао Зедуны төрсний 110 жилийн ойн хурал дээр уг үзэл баримтлалыг олон нийтийн өмнө анх тунхаглан зарласан бөгөөд Ерөнхий сайд Вэнь Зябао 2003 оны 11 дүгээр сард АНУ-д айлчлах үеэрээ Харвардын Их Сургууль дээр хэлсэн үгэндээ “Хятадын энх тайванч сэргэн мандал” үзэл

баримтлалыг хилийн чанадад тунхаглан зарлажээ.

Түүхийн үүднээс Хятадын өнөөгийн сэргэн мандлыг Британийн аж үйлдвэрийн хувьсгалтай харьцуулан үзэж энэ нь хүн төрөлхтөний түүхэнд зуун жилд нэг л удаа болдог зууны шинжтэй үйл явдал гэж бичиж байна. Соёлын үүднээс “Өөртөө хүсэхгүй байгаа зүйлийг хөршдөө бүү хий”, “Зөрчил маргаанаа хойш тавин энх амгаланг эрхэмлэн дээдэл” гэх зэрэг Хятадын уламжлалт үзэл санааг өвлөн авч, “power politics” болон “zero-sum game” зэрэг Өрнөдөд хөгжсөн уламжлалт улс төрийн үзэл баримтлалаас ангид “энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим” дээр үндэслэсэн “энх тайван ба хөгжил” гэсэн хандлагыг дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн үндсэн хандлага болгон хөгжүүлнэ гэж “Жэньминь жибао” сонин 2004 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн дугаартаа бичжээ.

Профессор Жэнь Бизян энэхүү Хятадын сэргэн мандлын хугацааг 1978 оны ХКН-ын бүгд хурлаас хойш 21 дүгээр зууны дунд хүртэл үргэлжлэх үйл явц гэж тодорхойлжээ. Түүний бичсэнээр Хятадын сэргэн мандлыг хэрэгжүүлэхийн тулд 3 хөдөлгөгч хүч болон 4 баталгаа хэрэгтэй гэжээ. Системийн тогтолцоо, шинжлэх ухаан, соёл иргэншил гурвыг байнга шинэчлэн боловсронгуй болгохыг эрмэлзэхээс гадна хүний нөөцийг хөгжүүлэх, нийгэмд тогтвортой тэнцвэртэй бүтэц бий болгох, батлан хамгаалах хүч чадлаа зузаатгах, бие даасан өөртөө түшиглэсэн энх тайванч гадаад бодлогыг хэрэгжүүлэх нь 4 баталгаа болох ёстой ажээ.

“Энх тайванч сэргэн мандал”-ын үзэл баримтлалын дотоод агуулга нь “сяокан” буюу хүн амын амьжиргааны түвшинг дэлхийн дундаж хэмжээнд хүргэх, гадаад агуулга нь дэлхийн энх тайвныг сахин хамгаалж, нийтийн хөгжлийг урагшлуулах гэж тодорхойлсон байна. Гадаад бодлогодоо

дэлхийн голлох орнууд, хөрш орнууд болон гуравдагч ертөнцийн орнуудыг тэргүүлэх чиглэл хэмээн үзжээ. Хөгжилтэй орнуудтай хамтын ашиг сонирхлыг бататгах үүднээс харилцааг урагшлуулах, хөрш орнуудтай “найз нөхөд болцгоон, түншлэх” зарчмаар харилцах, гуравдагч ертөнцийн орнуудтай эв нэгдэл, хамтын ажиллагаагаа өргөтгөх замаар дэлхийн улс төр, эдийн засгийн тогтолцоог шударга үндсэн дээр шинэчлэхийг эрмэлзэнэ гэжээ.

Сүүлийн үед Хятадын болон ЗӨА-ийн орнуудын эрдэмтэн судлаачид Зүүн Азийн хамтын нийгэмлэг гэдэг үзэл санааг дэвшүүлж, АСЕАН+3 гэсэн уулзалтын зэрэгцээ Зүүн Азийн дээд хэмжээний уулзалтыг (East Asia Summit) хийх саналыг өргөн дэвшүүлэх боллоо. Тухайлбал, 2004 онд Лаост болох 10+3 уулзалтын үеэр Зүүн Азийн дээд хэмжээний анхны уулзалтыг ёслолын байдалтай 30 минут хийж эхлүүлэх, 2005 онд Малайзид болох

уулзалтын үеэр Зүүн Азийн дээд хэмжээний албан ёсны уулзалтыг хийх санал яригдаж байна.

АСЕАН, Хятад, Япон, БНСУ-ын 100 гаруй судлаачид Бээжинд 2003 оны 9 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд хуралдаж, Зүүн Азийн судлаачдын сүлжээг (The Network of East Asian Think-tanks) байгуулсан байна. Тэд нар Зүүн Азийн дээд хэмжээний уулзалтад бэлтгэх, үүний тулд НБДГ байгуулах, Зүүн Азийн чөлөөт худалдааны бүс байгуулах талаарх судалгааг ойрын 2-3 жилд хийх зэрэг тодорхой асуудлуудыг хэлэлцэн санал солилцжээ. Судлаачид Зүүн Азийн алс хэтийн төлөвийг тодорхойлох зорилготой байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулсан 26 зүйлтэй төлөвлөгөөг (The Final Report of East Asia Study Group) хэлэлцэн өөрсдийнхөө үйл ажиллагааны хэтийн зорилтыг Зүүн Азийн хамтын нийгэмлэг (East Asia Community) байгуулах явдал мөн гэж тодорхойлжээ.